



МОНГОЛ УЛС

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа - 2018

ИНФОГРАФИК



НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА 2018

АГУУЛГА

1. Судалгааны хамралт, өрхийн шинж байдал
2. Амьдарч буй орчин
3. Амьдралын мөчлөг
 - Жирэмсэн ба төрөх үе
 - Амьдралын эхний арван жил
 - Амьдралын хоёр дахь арван жил
 - Насанд хүрэгчид

ИНФОГРАФИКТ АШИГЛАСАН ТЭМДЭГЛЭЛ

Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулсан графикт судалгаа тус бүрийн үр дүнг дараах өнгөөр илэрхийлсэн.

- Хүүхэд хөгжил судалгаа 2000 (ОУБТС2): Ногоон
- Хүүхэд хөгжил судалгаа 2005 (ОУБТС3): Саарал
- Хүүхэд хөгжил судалгаа 2010 (ОУБТС4): Хөх
- Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2013 (ОУБТС5): Улбар шар
- Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018 (ОУБТС6): Ягаан

Судалгааны хамралт, өрхийн шинж байдал

СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Судалгааг зохион байгуулсан байгууллага:
Үндэсний статистикийн хороо

Түүврийн хүрээ:
Хүн ам, өрхийн мэдээллийн сан 2017

Өрхийн жагсаалт гаргах:
2018 оны 8-9 сар

Ярилцлага авагчдад зориулсан сургалт:
2018 оны 8-9 сар

Мэдээлэл цуглуулалт:
2018 оны 9-12 сар

Асуулга:
Өрх
Эмэгтэй (15-49 нас)
Эрэгтэй (15-49 нас)
Тав хүртэлх насны хүүхэд
5-17 насны хүүхэд
Усны чанарын түршилт (Е.коли)

СУДАЛГААНЫ ТҮҮВЭР, ХАМРАГДАЛТЫН ТҮВШИН


Өрх		Тав хүртэлх насны хүүхэд	
• Түүвэрт сонгогдсон	14,500	• Хамрагдвал зохих	6,269
• Хамрагдвал зохих	14,041	• Бүрэн хамрагдсан	6,091
• Бүрэн хамрагдсан	13,798	• Хамрагдалтын түвшин (хувь)	97.2
• Хамрагдалтын түвшин (хувь)	98.3		
Эмэгтэй (15-49 нас)		5-17 насны хүүхэд	
• Хамрагдвал зохих	11,737	• Хамрагдвал зохих	7,628
• Бүрэн хамрагдсан	10,794	• Бүрэн хамрагдсан	7,427
• Хамрагдалтын түвшин (хувь)	92.0	• Хамрагдалтын түвшин (хувь)	97.4
Эрэгтэй (15-49 нас)		Усны чанарын түршилт (Е.коли)	
• Хамрагдвал зохих	5,513	• Хамрагдвал зохих	2,900
• Бүрэн хамрагдсан	4,477	• Бүрэн хамрагдсан	2,736
• Хамрагдалтын түвшин (хувь)	81.2	• Хамрагдалтын түвшин (хувь)	94.3

Судалгаанд хамрагдсан өрхийн хүн амын нас, хүйсийн суварга




Өрхөд амьдардаг хүн амын тархалтын хувь, насны бүлэг, хүйсээр, 2018 он.

Өрхийн тэргүүний шинж байдал



Өрхийн хувь, өрхийн тэргүүний сонгосон шинж байдлаар, 2018 он.


Өрхийн бүтэц



Өрхийн хувь, өрхийн гишүүдийн бүтцээр, 2018 он.

Амьдарч буй орчин

Өрхийн сууцны төрөл




Өрхийн хувь, үндсэн сууцны төрлөөр, 2018 он.

Моджуулсан давс хэрэглэдэг өрх



Хоолондоо ашигладаг давсны иодийн агууламж 15 мг/кг-аас дээш өрхийн хувь.




Цэвэр түлш, технологийн хэрэглээ, ТХЗ 7.1.2



Хоол хийх, халаалт, гэрэлтүүлэгтээ цэвэр түлш, технологи ашигладаг өрхөд амьдарч буй өрхийн хүн амын хувь, 2018 он.

Цэвэр түлш, технологи гэдэгт (ТХЗ 7.1.2) хоол хийхдээ ихэвчлэн цахилгаан зуух эсвэл газ, халаалтандаа төвлөрсөн халаалтын систем эсвэл сэргээгдэх эрчим хүч эсвэл цахилгаан халаагуур, гэрэлтүүлэгтээ цахилгаан, нарны зайн чийдэн, цэнэглэдэг эсвэл зай ашигладаг гар чийдэн ашигладаг бол хамаарна.

Ундны ус, ариун цэврийн байгууламж, гар угаах газрын суурь үйлчилгээ хангагдсан байдал



Өрхийн хувь, өрхийн ундны ус, ариун цэврийн байгууламж, гар угаах газрын үйлчилгээ хангагдсан байдлаар, 2018 он


Ундны усны үйлчилгээ: Суурь үйлчилгээ хангагдсан (ТХЗ 1.4.1) гэдэг нь сайжруулсан эх үүсвэртэй бөгөөд ус авахдаа 30 минутаас доош хугацаа зарцуулдаг. Сайжруулсан эх үүсвэр гэдэгт усыг аюулгүй байлгах нөхцлийг хангасан байхыг ойлгох бөгөөд үүнд: төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсон, хамгаалагдсан булаг шанд, хамгаалагдсан гүний худаг, хамгаалагдсан гар худаг, хурын ус, савласан ус, зөөврийн усны үйлчилгээ зэрэг багтана. **Хязгаарлагдмал** гэдэг нь сайжруулсан эх үүсвэртэй боловч ус авахдаа 30 ба түүнээс дээш минут зарцуулдаг. **Сайжруулаагүй эх үүсвэр** гэдэгт хамгаалагдаагүй гар худаг, хамгаалагдаагүй гүний худаг эсвэл хамгаалагдаагүй булаг шанд багтана. **Үйлчилгээ хангагдаагүй** гэдэгт гол, мөрөн, нуур, тойром, цөөрөм зэрэг гадаргын усыг ундны усны эх үүсвэрт ашиглаж байвал хамааруулна.

Ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ: Суурь үйлчилгээ хангагдсан (ТХЗ 1.4.1) гэж сайжруулсан ариун цэврийн байгууламж ашигладаг бөгөөд бусад өрх/хүнтэй хамтран ашигладаггүй байхыг хэлнэ. Сайжруулсан ариун цэврийн байгууламж нь бохирыг хүнтэй хүрэлцэхээс хамгаалсан буюу үүнд: нэгдсэн ариун цэврийн байгууламж руу урсдаг, битүү тунгаагуур руу урсдаг, нүхэн жорлон руу урсдаг ус татуургын бие засах газар, агааржуулагчтай сайжруулсан нүхэн жорлон, энгийн нүхэн жорлон, био жорлон зэрэг багтана. **Хязгаарлагдмал** гэдэгт сайжруулсан ариун цэврийн байгууламж хэрэглэдэг боловч бусад өрх/хүнтэй хамтарч ашигладаг тохиолдол багтана. **Сайжруулаагүй** ариун цэврийн байгууламж нь газрын гадарга руу урсдаг ус татуургын бие засах газар, задгай нүх зэрэг багтана. **Үйлчилгээ хангагдаагүй** гэдэгт хээрийн нөхцөлд бие засдаг тохиолдлыг ойлгоно.

Гар угаах газар: Суурь үйлчилгээ хангагдсан (ТХЗ 1.4.1 болон ТХЗ 6.2.1) гэдэгт өрхийн сууц, эргэн тойронд гар угаах тогтсон газартай бөгөөд түүнд нь саван, ус бэлэн байх нөхцөл багтана. Гар угаах газар нь суурилуулсан эсвэл хөдөлгөх боломжтой байж болох ба үүнд цорго бүхий угаалтуур, тосгуур, сэнжтэй аяга, данх зэрэг мөн багтана. Саван гэдэгт шахмал, шингэн саван, ариутгагч нунтаг зэрэг багтах ба хужир, элс зэрэг бусад гар угаахад хэрэглэгддэг бодис багтахгүй. **Хязгаарлагдмал** гэдэгт гар угаах газар байдаг хэдий ч ус болон/эсвэл саван байхгүй тохиолдол багтана. **Гар угаах газаргүй** гэж тухайн өрхийн сууц, эргэн тойронд гар угаах газар байхгүй тохиолдлыг хэлнэ.

Аюулгүй зохион байгуулагдсан ундны усны суурь үйлчилгээ хангагдсан байдал, ТХЗ 6.1.1


Сайжруулсан, суурь үйлчилгээ хангагдсан, аюулгүй зохион байгуулагдсан ундны усны үйлчилгээний хамралт



Сайжруулсан, суурь үйлчилгээ хангагдсан, аюулгүй зохион байгуулагдсан ундны усны үйлчилгээ хэрэглэж байгаа хүн амын хувь, 2018 он.

Аюулгүй зохион байгуулагдсан (ТХЗ 6.1) гэдэгт сайжруулсан эх үүсвэртэй бөгөөд өрхийн сууц/ хашаанд байдаг, хэрэгцээтэй үед ус хангалттай хэмжээнд бэлэн байдаг, бохирдоогүй эх үүсвэртэй байхыг ойлгоно.

Ундны усны үйлчилгээний хамралт




Хүн амын хувь, хэрэглэж буй ундны усны үйлчилгээний төрлөөр, 2018 он.

ЖИРЭМСЭН ҮЕ



Жирэмсний хяналтад анх үзүүлсэн хугацаа



Судалгаанаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн бөгөөд хамгийн сүүлд төрүүлсэн хүүхдээ тээх үедээ мэргэжлийн эмчид наад зах нь нэг удаа үзүүлсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, жирэмсний хяналтад анх үзүүлсэн хугацаагаар, 2018 он



Жирэмсний хяналтад үзүүлсэн тоо




Судалгаанаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, жирэмсний хяналтад үзүүлсэн тоогоор, 2018 он.

Он	Жирэмсний хяналтад эрт үзүүлсэн (эхний 3 сард)			4, түүнээс олон удаа жирэмсний хяналтад үзүүлсэн, ТХЗ 3.8.1		
	Улсын дүн	Хот	Хөдөө	Улсын дүн	Хот	Хөдөө
2010	77.2	80.1	72.7	81.4	82.4	80.0
2013	78.8	82.7	72.1	89.4	92.0	85.4
2018	83.8	85.1	80.8	88.5	89.7	85.9

Судалгаанаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн бөгөөд хамгийн сүүлд төрүүлсэн хүүхдээ тээх үедээ мэргэжлийн эмчид жирэмсний эхний 3 сарын дотор үзүүлсэн; жирэмсний хяналтад 4, түүнээс олон удаа үзүүлсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, хот, хөдөөгөөр.

ЖИРЭМСНИЙ ХЯНАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН



Судалгаанаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн бөгөөд жирэмсний хяналтад үзүүлэхдээ дээр дурдсан шинжилгээг өгч, зөвлөгөө авсан 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, 2018 он.

ТӨРӨХ ҮЕИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

99.3

Мэргэжлийн эмч эх барьсан, ТХЗ 3.1.2





98.4

Хүүхдээ эмнэлэгт төрүүлсэн



99.3

Төрсөн даруй хүүхдийг нь жинлэсэн



Судалгаанаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн бөгөөд хамгийн сүүлийн хүүхдээ төрүүлэх үед мэргэжлийн эмч эх барьсан, хүүхдээ эмнэлэгт төрүүлсэн, төрсөн даруй хүүхдийг нь жинлэсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь.

Мэргэжлийн эмч гэдэгт эх барих эмэгтэйчүүдийн эмч, бусад мэргэжлийн их эмч, өрх/сумын эмч, эх баригч, бага эмч, сувилагч зэрэг багтана.

МЭС ЗАСЛЫН АРГААР ХҮҮХЭД ТӨРҮҮЛЭХ



Судалгаанаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн бөгөөд хамгийн сүүлийн хүүхдээ мэс заслын аргаар төрүүлсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь.

Тэмдэглэл: 2018 оны судалгааны үр дүнг бүсээр, хот, хөдөөгөөр, төрөх үеийн эхийн насаар ангилан харуулсан.

ТӨРСНИЙ БҮРТГЭЛ, ТХЗ 16.9.1




99.6

Төрсний бүртгэлтэй

Улсын дүн	2005	2010	2013	2018
Улсын дүн	98.0	99.0	99.3	99.6

Төрснийг нь бүртгүүлсэн 5 хүртэлх насны хүүхдийн хувь.

БАГА ЖИНТЭЙ ТӨРӨЛТ




Улсын дүн	2005	2010	2013	2018
Улсын дүн	5.5	4.7	5.2	4.6

Судалгаанаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн, хамгийн сүүлд төрүүлсэн хүүхдийг нь төрсөн даруй жинлэсэн бөгөөд 2500 граммаас бага жинтэй төрсөн гэж мэдээлсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь.

Тэмдэглэл: 2018 оны судалгааны үр дүнг бүсээр ангилан харуулсан.

ТӨРСНИЙ ДАРААХ НЯРАЙН ҮЗЛЭГ



Судалгаанаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн, хамгийн сүүлийн хүүхдээ төрүүлэх үед хүүхдийг төрсөн даруйд арчиж хуурайшуулсан, дулаан байлгах асаргаа хийсэн, 24-өөс дээш цагийн дараа усанд оруулсан, төрсний дараах хяналтын үзлэгээр наад зах нь 2 төрлийн үйлчилгээ эсвэл зөвлөгөө авсан, төрснөөс хойш 1 цагийн дотор хүүхдийг нь амлуулсан 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, 2018 он.

ТӨРСНИЙ ДАРААХ ХЯНАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ

ТӨРСНӨӨС ХОЙШ 2 ХОНОГТ

98.2 Хүүхдийг үзсэн

94.1 Эхийг үзсэн

ТӨРСНИЙ ДАРААХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮРДЭЛ



Эхийн сүүгээр хооллох талаар зөвлөгөө өгсөн **79.0**

Хүүхдээ хөхүүлж байгааг ажигласан **59.9**

Эхийн халууныг хэмжсэн **83.7**

Нярайг жинлэсэн **34.3**

Хүйг шалгасан **89.9**

Төрсний дараах хяналтын үзлэгээр наад зах нь 2 төрлийн үйлчилгээ, зөвлөгөө авсан хүүхдийн хувь **93.8**

Судалгаанаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн, төрснөөс хойш 2 хоногт хүүхдийн болон эхийн эрүүл мэндийн байдлыг эмнэлэгт эсвэл гэрт нь үзсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, 2018 он.

Судалгаанаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн, төрснөөс хойш 2 хоногийн хугацаанд эмнэлгийн мэргэжилтэн хүүхдийн хүйг шалгасан, эхийн халууныг нь хэмжсэн, хүүхдийг жинлэсэн, эхийн сүүгээр хооллох талаар зөвлөгөө өгсөн, хүүхдээ хөхүүлж байгааг нь ажигласан, аюултай шинж тэмдэг илэрсэн үед эмнэлэгт хандах талаар мэдээлэл өгсөн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, 2018 он.


Он	Төрснөөс хойш 2 хоногт эхийг үзсэн			Төрснөөс хойш 2 хоногт хүүхдийг үзсэн		
	Улсын дүн	Хот	Хөдөө	Улсын дүн	Хот	Хөдөө
2013	95.4	95.7	94.8	98.6	98.9	98.2
2018	94.1	93.3	95.9	98.2	98.3	97.8

Судалгаанаас өмнөх 2 жилд хүүхэд төрүүлсэн, төрснөөс хойш 2 хоногт хүүхдийн болон эхийн эрүүл мэндийн байдлыг эмнэлгийн мэргэжилтэн эмнэлэгт эсвэл гэрт нь үзсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, хот, хөдөөгөөр.

АМЬДРАЛЫН МӨЧЛӨГ: Амьдралын эхний 10 жил

Хүүхдийн бага насан дахь хоол тэжээл, дэмжлэг үзүүлэх орчин нь хүүхдийн эрүүл мэнд, эндэгдлээс сэргийлэх болон бие бялдар, суралцах чадвар хөгжихөд түлхүүр хүчин зүйлс болдог. Суралцах чадвар хязгаарлагдмал өссөн хүүхэд ирээдүйд сэтгэлзүйн эрүүл мэндийн асуудалд өртөх, амжилтгүй суралцах, сургуулиас завсардах, ур чадваргүй ажил эрхлэх, өөрийн хүүхдээ муу халамжлах эрсдлийг нэмэгдүүлдэг. Эцэг, эх, асран хамгаалагчтайгаа харилцах, дэмжлэг авах нь тархины хөгжлийг хурдасгаж, хүүхэд насанд эерэгээр нөлөөлдөг.

НЯРАЙ, БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХООЛ ТЭЖЭЭЛ



Эрт амлуулалт: Төрсний дараа 1 цагийн дотор ангир уургаа амласан хүүхдийн хувь; **Эхийн сүүгээр дагнан хооллож байгаа:** Зөвхөн эхийн сүүгээр хооллож байгаа 0-5 сартай хүүхдийн хувь; **Нэмэгдэл хоол идэж байгаа:** нэмэгдэл хоол идэж байгаа 6-8 сартай хүүхдийн хувь; **Зохих нэр төрлийн хүнс хэрэглэж байгаа:** Зөвлөсөн 8 төрлийн хүнсний бүлгээс - үүнд 1) эхийн сүү, 2) үр тариагаар хийсэн хүнс, хүнсний бүтээгдэхүүн, 3) буурцаг, шош, самар, 4) сүү, сүүн бүтээгдэхүүн (сүү, хүүхдийн тэжээл, тараг, бяслаг), 5) мах (мал, гахай, шувууны мах, дотор мах), 6) өндөг, 7) А аминдэмээр баялаг жимс, хүнсний ногоо, 8) бусад жимс, хүнсний ногоо - наад зах нь 5 төрлийн орцоор хооллосон 6-23 сартай хүүхдийн хувь; **Зохих давтамжаар хооллож байгаа:** Зөвлөмжийн дагуу хүүхдийн насанд тохирсон давтамжаар өтгөн, шингэн хоолоор хооллож байгаа 6-23 сартай хүүхдийн хувь; **Зохистой байдлаар хооллож байгаа:** Зохистой давтамжаар хооллож байгаа бөгөөд зохих нэр төрлийн хүнс хэрэглэж байгаа 6-23 сартай хүүхдийн хувь; **1 нас хүртэл эхийн сүүгээр хооллож байгаа:** Эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож байгаа 12-15 сартай хүүхдийн хувь, **2 нас хүртэл эхийн сүүгээр хооллож байгаа:** Эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож байгаа 20-23 сартай хүүхдийн хувь.


ДАРХЛААЖУУЛАЛТ

Нас	Он	Сүрьеэ (БЦЖ)	Хепатит Б төрөх үеийн тун	Халдварт саа			Тавт			УГУ		Хепатит А		Суурь вакцин	Бүрэн вакцин	
				Төрөх үеийн тун	1	2	3	1	2	3	1	2	1			2
12-23 сартай хүүхэд	2005	97.6	-	-	97.6	96.7	94.2	93.6	94.4	93.2	88.2	-	-	-	81.7	-
	2010	97.9	96.7	97.9	97.7	96.6	93.8	95.6	94.5	92.4	87.8	-	-	-	77.4	-
	2013	99.3	99.1	99.3	98.9	98.3	97.6	99.1	98.5	98.0	94.2	-	-	-	93.0	-
	2018	98.0	98.5	97.9	97.3	93.7	92.0	97.0	94.0	91.9	91.6	-	-	-	86.9	-
24-35 сартай хүүхэд	2013	97.6	97.4	97.5	97.6	96.6	95.9	97.9	96.9	96.2	94.5	-	-	-	91.8	-
	2018	96.7	97.1	96.7	96.3	94.2	91.3	95.5	93.3	90.9	92.2	81.2	85.4	72.5	85.8	67.1

Үндэсний дархлаажуулалтын товллын дагуу судалгаанаас өмнө вакцин хийлгэсэн (бохир жин) 12-23 сартай болон 30-35 сартай хүүхдийн хувь.

Суурь дархлаажуулалт: БЦЖ (Сүрьеэ), Саа – төрөх үеийн тун, Хепатит Б – төрөх үеийн тун, Саа 1-3, Тавт 1-3, Улаанбурхан, гахайн хавдар, улаанууд (УГУ)1; **Бүрэн дархлаажуулалт:** БЦЖ (Сүрьеэ), Саа – төрөх үеийн тун, Хепатит Б – төрөх үеийн тун, Саа 1-3, Тавт 1-3, Хепатит А1-2, УГУ1-2.

ДАРХЛААЖУУЛАЛТ: ТХЗ-ЫН ҮЗҮҮЛЭЛТ 3.в.1, 3.8.1



Үндэсний дархлаажуулалтын товллын дагуу судалгаанаас өмнө вакцин хийлгэсэн (бохир жин) 12-23 сартай болон 30-35 сартай хүүхдийн хувь, 2018 он.
Суурь дархлаажуулалт: БЦЖ (Сүрьеэ), Саа – төрөх үеийн тун, Хепатит Б – төрөх үеийн тун, Саа 1-3, Тавт 1-3, Улаанбурхан, гахайн хавдар, улаанууд (УГҮ)1;
Бүрэн дархлаажуулалт: БЦЖ (Сүрьеэ), Саа – төрөх үеийн тун, Хепатит Б – төрөх үеийн тун, Саа 1-3, Тавт 1-3, Хепатит А1-2, УГҮ1-2.

ХООЛ ТЭЖЭЭЛИЙН ДУТЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ӨСӨЛТ ХОЦРОЛТТОЙ, ТХЗ 2.2.1



9.4

Насандаа тохирсон өндрөөс хэт намхан хүүхдийг хэлнэ.

Өсөлт хоцролттой 5 хүртэлх насны хүүхдийн хувь

ТУРАНХАЙ, ТХЗ 2.2.2




0.9

Өндөртөө тохирсон жингээс хэт бага жинтэй хүүхэд

Туранхай 5 хүртэлх насны хүүхдийн хувь

ИЛҮҮДЭЛ ЖИНТЭЙ, ТХЗ 2.2.2



10.5

Өндөртөө тохирсон жингээс хэт их жинтэй хүүхэд

Илүүдэл жинтэй 5 хүртэлх насны хүүхдийн хувь


ТУРААЛТАЙ ХҮҮХЭД



1.8

Тураалтай болон Өсөлт хоцролттой хүүхдийн шинж байдлыг агуулсан хоол тэжээлийн дутлын үзүүлэлт


Тураалтай 5 хүртэлх насны хүүхдийн хувь



5 хүртэлх насны хүүхдийн хувь, жин, өндрийн хэмжилтийн 3 харьцаанд суурилсан (насандаа тохирсон жин, насандаа тохирсон өндөр, өндөртөө тохирсон жин) хүүхдийн хоол тэжээлийн үзүүлэлтээр.


БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС, ТХЗ 4.2.1



(1) Цагаан толгойн үсэг, тоо нэрлэх (2) Бие, бялдрын хөгжил (3) Нийгэмшихүй болон сэтгэл хөдлөлөө илэрхийлэх (4) Суралцах гэсэн 4 үзүүлэлтээс наад зах нь 3 үзүүлэлтийн хувьд зохих түвшинд байгаа 3-4 насны хүүхдийн хувь. **Тэмдэглэл:** 2018 оны судалгааны үр дүнг хүйсээр, хот, хөдөөгөөр ангилан харуулсан.

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ИНДЕКС (МУ-ЫН ТОДОРХОЙЛОЛТООР)




Монгол Улсын сургуулийн өмнөх боловсролын ЦӨМ хөтөлбөрт цагаан толгойн үсэг нэрлэх, энгийн үгсийг унших зэрэг чадварыг багтаадаггүй тул өөрийн улс орны онцлогийг тусгасан зарим асуултыг асуулгад нэмж оруулж тооцсон.

ХҮҮХДИЙН АМЬДАРЧ БҮЙ ОРЧИН




0-17 насны хүүхдийн хувь, төрсөн эцэг, эхтэйгээ амьдарч буй байдлаар, 2018 он.


НАСАНД ХҮРЭГЧДИЙН ЗҮГЭЭС ҮЗҮҮЛЖ БҮЙ ДЭМЖЛЭГ



Судалгаанаас өмнөх 3 өдөрт өрхийн хэн нэг насанд хүрсэн гишүүн хүүхдийн суралцах, сургуульд бэлтгэгдэхэд тусгайлан цаг гаргасан 2-4 насны хүүхдийн хувь, цаг гаргасан хүний хамаарлаар. **Тэмдэгдлэл:** Үйл ажиллагаануудад хүүхдэд ном уншиж өгөх; үлгэр ярьж өгөх; дуу дуулж, бүүвэйлэх; гадаа авч гаран зугаалах; хамт тоглох; хамтдаа эд юмсыг нэрлэж, тоо тоолж, зураг зурах зэрэг багтана.



Судалгаанаас өмнөх 3 өдөрт өрхийн хэн нэг насанд хүрсэн гишүүн хүүхдийн суралцах, сургуульд бэлтгэгдэхэд тусгайлан цаг гаргасан 2-4 насны хүүхдийн хувь, хот, хөдөөгөөр, цаг гаргасан хүний хамаарлаар, 2018 он.



Судалгаанаас өмнөх 3 өдөрт өрхийн хэн нэг насанд хүрсэн гишүүн хүүхдийн суралцах, сургуульд бэлтгэгдэхэд тусгайлан цаг гаргасан 2-4 насны хүүхдийн хувь, хүүхдийн хүйсээр, цаг гаргасан хүний хамаарлаар, 2018 он.

СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, ТОГЛОХ ЭД ЗҮЙЛС




28.6

Гэртээ 3, түүнээс олон хүүхдийн номтой 5 хүртэлх насны хүүхдийн хувь.




65.1

Гэртээ 2, түүнээс олон төрлийн тоглох зүйлтэй 5 хүртэлх насны хүүхдийн хувь.



37.4

Гар утас, таблет, компьютерээр тоглодог 5 хүртэлх насны хүүхдийн хувь.



3, түүнээс олон хүүхдийн номтой, 2, түүнээс олон төрлийн тоглох зүйлтэй 5 хүртэлх насны хүүхдийн хувь.

Судалгаанаас өмнөх 7 хоногт наад зах нь нэг удаа нэгээс олон цагаар ганцааранг нь эсвэл 10 хүртэлх насны хүүхдээр харуулж үлдээсэн 5 хүртэлх насны хүүхдийн хувь.

СУРАЛЦАХ

Чанартай сургуулийн өмнөх боловсролд хүүхдийг хамруулснаар тэдний суралцах чадварыг сайжруулах бөгөөд анги улирах болон сургуулиас завсардалтыг бууруулж, амжилт гаргахад эерэг нөлөө үзүүлдэг. Бага боловсрол нь хүний насан туршид суралцах суурь болдог.



Сургуулийн өмнөх боловсролд хамрагдал



Зохион байгуулалттай сургалтад хамрагдал, ТХЗ 4.2.2

Бага боловсролд хамрагдал



Бага боловсрол эзэмшилт



69.0

88.3

97.0

99.4



67.3

80.2

95.1

97.5

Сургуулийн өмнөх боловсролд хамрагддаг 24-59 сартай хүүхдийн хувь, хүйсээр



Хичээлийн жилийн эхэнд 5 настай (1-р ангид элсвэл зохих наснаас нэгээр бага) байсан бөгөөд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа эсвэл бага ангид сурч байгаа хүүхдийн хувь (хамран сургалтын цэвэр жин), хүйсээр

Бага эсвэл дунд ангид сурч байгаа 6-10 насны (бага ангид сурах албан ёсны нас) хүүхдийн хувь (хамран сургалтын цэвэр жин), хүйсээр

Бага боловсрол эзэмшсэн 13-15 насны хүүхдийн хувь, хүйсээр

СУРАХ СУУРЬ ЧАДВАР, ТХЗ 4.1.1

2, 3-р ангид сурч байгаа бөгөөд дараах үйлдлүүдийг амжилттай хийсэн хүүхдийн хувь:




Унших чадвар: 1) Өгөгдсөн эх доторх үгийн 90, түүнээс дээш хувийг зөв уншсан, 2) шууд хариулах 3 асуултад зөв хариулсан, 3) учир шалтгаан тодруулсан 2 асуултад зөв хариулсан 2, 3-р ангид сурдаг хүүхдийн хувь, хүйсээр, 2018 он.

Тоо бодох чадвар: 1) тоо таних, 2) тоо жиших, 3) нэмэх үйлдэл, 4) зүй тогтлыг олох дасгалуудыг зөв хийсэн 2, 3-р ангид сурдаг хүүхдийн хувь, хүйсээр, 2018 он.

ХҮЧРХИЙЛЭЛ, МӨЛЖЛӨГӨӨС ХАМГААЛАГДАХ

Сэтгэл санааны болон бие махбодийн шийтгэл, ТХЗ 16.2.1



Судалгаанаас өмнөх 1 сард сэтгэл санааны болон бие махбодийн шийтгэл хүлээсэн 1-14 насны хүүхдийн хувь, мөн хүүхдийг хүмүүжүүлэхэд бие махбодийн шийтгэл хэрэгтэй гэж боддог эцэг эх/асран хамгаалагчийн хувь.


Тэмдэглэл: 2010 оны судалгааны үр дүн 2-14 насны хүүхдийн хувьд тооцогдсон.

Сүүлийн 1 сард сэтгэл санааны болон бие махбодийн шийтгэл хүлээсэн 1-14 насны хүүхдийн хувь, хүйсээр, 2018 он

Амьдралын мөчлөг: Амьдралын хоёр дахь 10 жил

Суурь боловсрол эзэмших нь ирээдүйд олох орлого, үндэсний эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлж, эрт гэрлэлт, өсөлт хоцролт, эх, хүүхдийн эндэгдлийг бууруулахад чухал нөлөөтэй байдаг. Өсвөр насны охид, хөвгүүд хувийн аюулгүй байдлаа ялгаатайгаар хардаг ба энэ нь бэлгийн хүчирхийлэл, бусад гэмт хэрэг зэрэг жендэрт суурилсан аюулд өртөх магадлалтай холбоотой. Мөн өсвөр нас бол жендэрийн хэм хэмжээ төлөвшдөг үе бөгөөд энэ үед охид, хөвгүүдэд сэтгэлзүйн эрүүл мэндийн өөрчлөлт бий болох эрсдэлт хүчин зүйлстэй тулгардаг. Иймд өсвөр насны охид, хөвгүүдийн амьдралын сэтгэл ханамжийг хэмжих нь тэдний сэтгэлзүйн эрүүл мэндийн талаар чухал мэдээллийг бий болгох юм.


СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ БА БОЛОВСРОЛ ЭЗЭМШИЛТ

		Дунд ангид хамрагдалт	Суурь боловсрол эзэмшилт	Ахлах ангид хамрагдалт	Бүрэн дунд боловсрол эзэмшилт
	Хөдөө	96.6	95.6	86.1	75.0
	Хот	92.9		93.5	
	Хөдөө	90.1	89.3	66.7	65.9
	Хот	92.9		89.9	

Дунд ангид хамрагдалт: Дунд анги болон түүнээс дээш боловсролын түвшинд суралцаж байгаа 11-14 насны (дунд ангид сурах албан ёсны нас) хүүхдийн хувь (хамран сургалтын цэвэр жин). **Суурь боловсрол эзэмшилт:** Суурь боловсрол эзэмшсэн 17-19 насны хүн амын хувь. **Ахлах ангид хамрагдалт:** Ахлах ангид болон түүнээс дээш боловсролын түвшинд суралцаж байгаа 15-17 насны (ахлах ангид сурах албан ёсны нас) хүүхдийн хувь (хамран сургалтын цэвэр жин). **Бүрэн дунд боловсрол эзэмшилт:** Бүрэн дунд боловсрол эзэмшсэн 20-22 насны хүн амын хувь.

СУРАХ СУУРЬ ЧАДВАР


Унших болон тоо бодох суурь чадвартай хүүхдийн хувь, ангиар:



Унших чадвар: 1) Өгөгдсөн эх доторх үгийн 90, түүнээс дээш хувийг зөв уншсан, 2) шууд хариулах 3 асуултад зөв хариулсан, 3) учир шалтгаан тодруулсан 2 асуултад зөв хариулсан 7-14 насны хүүхдийн хувь

Тоо бодох чадвар: 1) тоо таних, 2) тоо жиших, 3) нэмэх үйлдэл, 4) зүй тогтлыг олох дасгалуудыг зөв хийсэн 7-14 насны хүүхдийн хувь

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР, ТХЗ 8.7.1*



Хүүхдийн хөдөлмөр эрхэлж байгаа 5-17 насны хүүхдийн хувь.

Тэмдэглэл: 2018 оны судалгааны үр дүнг хүйс, хот, хөдөө, сургуульд хамрагдалтаар ангилан харуулсан.

*ОУБТС-ны хүүхдийн хөдөлмөрийн үзүүлэлтийн тооцоо нь ТХЗ-ын 8.7.1 үзүүлэлтийн тооцооноос ялгаатай бөгөөд ТХЗ-ын мэдээллийн сан нь хөдөлмөрийн аюултай нөхцлийг тооцдоггүй, мөн 5-14 насны хүүхдийн хувьд хүүхдийн хөдөлмөр гэж үзэх гэрийн ажилд зарцуулсан цагийн доод хэмжээг 21 гэж тогтоосон байдаг бол 15-17 насны хүүхдийн хувьд гэрийн ажлын цагийн доод хэмжээг тогтоогоогүй байдаг.

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТӨРӨЛ



Гэрийн ажил



Эдийн засгийн үйл ажиллагаа



Аюултай нөхцөл



6.1

6.5

5.4



7.1

9.1

10.0

Хүүхдийн хөдөлмөр эрхэлдэг 5-17 насны хүүхдийн хувь, үйл ажиллагааны төрлөөр, 2018 он.

Тэмдэглэл: Эдгээр мэдээлэл нь дээрх ажлын төрлүүдэд тухайн хүүхдийн насанд харьцах цагийн доод хязгаараас илүү цаг зарцуулсан хүүхдийн хувийг харуулсан болно. Насанд харьцах цагийн доод хязгаарын талаарх мэдээллийг «Хүүхдийн хөдөлмөрийн тодорхойлолт»-оос харна уу.

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТОДОРХОЙЛОЛТ

5-11 нас: Долоо хоногт наад зах нь 1 цаг эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон эсвэл наад зах нь 28 цаг гэрийн ажил хийсэн, эсвэл аюултай нөхцөлд ажилладаг.

12-14 нас: Долоо хоногт наад зах нь 14 цаг эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон, эсвэл наад зах нь 28 цаг гэрийн ажил хийсэн, эсвэл аюултай нөхцөлд ажилладаг.

15-17 нас: Долоо хоногт наад зах нь 43 цаг эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон, эсвэл наад зах нь 43 цаг гэрийн ажил хийсэн, эсвэл аюултай нөхцөлд ажилладаг.

Эдийн засгийн үйл ажиллагаа гэдэгт өрхөөс гадуур эсвэл өрхийн мал аж ахуй, бизнест хөлстэй болон хөлсгүй ажил хийх орно. Гэрийн ажилд хоол хийх, гэр цэвэрлэх, хүүхэд асрах, түлээ түлш бэлтгэх, усанд явах зэрэг ажлууд орно.

ХОХИРСОН БАЙДАЛ



Судалгаанаас өмнөх 12 сард дээрэм, бие махбодийн халдлага, хулгай, залиланд өртсөн 15-19 насны залуучуудын хувь, хүйсээр, 2018 он.

ДЭЭРЭМ, БИЕ МАХБОДИЙН ХАЛДЛАГАД ӨРТСӨНӨӨ ЦАГДААД БҮРТГҮҮЛСЭН БАЙДАЛ, ТХЗ 16.3.1



32.3




12.6



Судалгаанаас өмнөх 12 сард хамгийн сүүлд өртсөн дээрэм, бие махбодийн халдлагын талаар цагдаагийн байгууллагад мэдээлсэн 15-19 насны залуучуудын хувь, хүйсээр, 2018 он.

АЮУЛГҮЙ МЭДРЭМЖ, ТХЗ 16.1.4



Харанхуйд гэрийнхээ ойр орчимд ганцаараа явахад аюулгүй гэж боддог 15-19 насны залуучуудын хувь, хүйсээр, 2018 он.

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ



Компьютер



Гар утас



Интернэт,
ТХЗ 17.8.1



53.7

97.2

93.0




52.1

88.9


84.4

Судалгаанаас өмнөх 3 сард компьютер, гар утас, интернэт хэрэглэсэн 15-19 насны залуучуудын хувь, хүйсээр, 2018 он.


ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭ, ТХЗ 3.А.1



СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ




ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ, ТХЗ 10.3.1




Судалгаанаас өмнөх 12 сард ялгаварлан, гадуурхалт мэдэрсэн 15-19 насны залуучуудын, хувь хүйсээр, 2018 он.

АМЬДРАЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖ



15-19 насны залуучуудын амьдралын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ (0-10 хооронд үнэлсэн), хүйсээр, насны бүлгээр, 2018 он.

ХҮҮХДИЙН ГЭРЛЭЛТ, ТХЗ 5.3.1



15 болон 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн 20-24 насны эмэгтэйчүүдийн хувь, 2018 он.


Тэмдэглэл: Монгол Улсын «Гэр бүлийн тухай» хуулинд гэрлэх доод насыг 18 гэж заасан байдаг. Энд бичигдсэн хүүхдийн гэрлэлт гэдгийг хамтран амьдарч байгааг ойлгоно.




15 болон 18 нас хүрэхээсээ өмнө гэрлэсэн 20-24 насны эмэгтэйчүүдийн хувь.

Тэмдэглэл: Монгол Улсын «Гэр бүлийн тухай» хуулинд гэрлэх доод насыг 18 гэж заасан байдаг. Энд бичигдсэн хүүхдийн гэрлэлт гэдгийг хамтран амьдарч байгааг ойлгоно.

ӨСВӨР НАСНЫ ОХИДЫН ТӨРӨЛТИЙН ТҮВШИН, ТХЗ 3.7.2



15-19 насны охидын төрөлтийн түвшин, судалгаанаас өмнөх 3 жилийн хугацаагаар, хот, хөдөөгөөр.




15-19 насны охидын төрөлтийн түвшин, судалгаанаас өмнөх 3 жилийн хугацаагаар, сонгосон үзүүлэлтээр, 2018 он.


Тогтвортой хөгжлийн зорилт 3.7-г «2030 он гэхэд гэр бүл төлөвлөлт, мэдээлэл, мэдлэг өгөх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлыг үндэсний бодлого, хөтөлбөр тусгах зорилгоор бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэх» гэж томъёолсон байдаг бөгөөд үүнд ТХЗ-ын 3.7.2 буюу өсвөр насны охидын төрөлтийн түвшин гэсэн үзүүлэлт хамаарна. Өсвөр насны охидын төрөлтийг бууруулж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсэд анхаарал хандуулснаар өсвөр насныхны бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулж, нийгэм, эдийн засгийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх юм. Эмэгтэйчүүдийг эрт төрөхөөс сэргийлэх нь эхийн эрүүл мэндийг сайжруулах болон нялхсын эндэгдлийг бууруулахад авч болох чухал арга хэмжээ юм

АМЬДРАЛЫН МӨЧЛӨГ: Насанд хүрэгчид

ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ХЭРЭГЛЭЭ



МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ




Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг (сонин, сэтгүүл, ФМ, радио, телевиз) долоо хоногт наад зах нь 1 удаа хэрэглэдэг 15-49 насны хүн амын хувь, хүйсээр, 2018 он.

Судалгаанаас өмнөх 3 сард компьютер, гар утас, интернэт хэрэглэсэн 15-49 насны хүн амын хувь, хүйсээр, 2018 он.

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ АШИГЛАХ ЧАДВАР, ТХЗ 4.4.1

- Ямар нэг программчлалын хэлээр компьютерийн программ бичих
 - Модем, камер, принтер зэрэг шинэ төхөөрөмжийг таниулж, суулгах
 - Текст, зураг, дуу, видео, график ашиглан илтгэл бэлтгэх
 - Эксель дээр энгийн арифметик томъёоллыг ашиглах
 - Программ хайх, татах, суулгах, тохируулах
 - Компьютер болон бусад төхөөрөмжийн хооронд файл дамжуулах
 - Файл, зураг, бичлэг зэргийг хавсарган цахим шуудангаар илгээх
 - Файл/ фолдер хуулж, зөөх
 - Нэг файл доторх текстийг хуулж, зөөх
- *Тусгайлсан 9 үйлдлээс наад зах нь нэгийг нь хийсэн



Судалгаанаас өмнөх 3 сард компьютер ашиглахтай холбоотой тусгайлсан үйлдлүүдийг хийсэн 15-49 насны хүн амын хувь, мөн тусгайлсан 9 үйлдлийн наад зах нь нэгийг хийсэн 15-49 насны хүн амын хувь, хүйсээр, 2018 он.

*ТХЗ 4.4.1: Мэдээлэл, харилцаа, холбооны технологи ашиглах чадвар (тусгайлсан 9 үйлдлийн наад зах нь нэгийг хийсэн)


ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ХЭРЭГЛЭЭ

Он	Эрэгтэйчүүд (долоо хоногт наад зах нь 1 удаа):				Эмэгтэйчүүд (долоо хоногт наад зах нь 1 удаа):			
	Сонин, сэтгүүл унших	ФМ, радио сонсох	Зурагт үзэх	3 мэдээллийн хэрэгслийг хэрэглэдэг	Сонин, сэтгүүл унших	ФМ, радио сонсох	Зурагт үзэх	3 мэдээллийн хэрэгслийг хэрэглэдэг
2010	42.2	46.4	95.8	23.6	47.6	40.2	94.3	23.4
2013	38.3	30.8	96.8	13.1	47.8	18.6	96.0	9.5
2018	18.7	31.4	89.1	7.5	19.1	17.9	89.6	4.5

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг (сонин, сэтгүүл, ФМ, радио, зурагт) долоо хоногт наад зах нь 1 удаа хэрэглэдэг 15-49 насны хүн амын хувь, хүйсээр. Тэмдэглэл: 2010 оны судалгааны эрэгтэйчүүдийн үзүүлэлт 15-54 насны хувьд тооцогдсон.


АЮУЛГҮЙ БАЙДАЛ

ГЭРИЙНХЭЭ ОЙР ОРЧИМД ГАНЦААРАА АЛХАХАД АЮУЛГҮЙ ГЭЖ БОДДОГ, ТХЗ 16.1.4




Харанхуйд гэрийнхээ ойр орчимд ганцаараа алхахад аюулгүй гэж боддог 15-49 насны хүн амын хувь, хүйсээр, хот, хөдөөгөөр, 2018 он.

ГЭРТЭЭ ГАНЦААРАА БАЙХДАА АЮУЛГҮЙ ГЭЖ БОДДОГ




Харанхуйд гэртээ ганцаараа байхад аюулгүй гэж боддог 15-49 насны хүн амын хувь, хүйсээр, хот, хөдөөгөөр, 2018 он.

ХОХИРСОН БАЙДАЛ




Судалгаанаас өмнөх 12 сард дээрэм, бие махбодийн халдлага, хулгай, залиланд өртсөн 15-49 насны хүн амын хувь, хүйсээр, 2018 он.

ДЭЭРЭМ, БИЕ МАХБОДИЙН ХАЛДЛАГАД ӨРТСӨНӨӨ ЦАГДААД БҮРТГҮҮЛСЭН БАЙДАЛ, ТХЗ 16.3.1



Судалгаанаас өмнөх 12 сард хамгийн сүүлд өртсөн дээрэм, бие махбодийн халдлагын талаар цагдаагийн байгууллагад мэдээлсэн 15-49 насны хүн амын хувь, хүйсээр, 2018 он.


ХАМГИЙН СҮҮЛИЙН БИЕ МАХБОДИЙН ХАЛДЛАГАД ӨРТСӨН ГАЗАР



Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд бие махбодийн халдлагад өртсөн 15-49 насны хүн амын хувь, хамгийн сүүлийн бие махбодийн халдлагад өртсөн газраар, хүйсээр, 2018 он.


ЭРЭГТЭЙЧҮҮД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХАНДЛАГА, ХҮЛЭЭЛТ

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ХАНДАХ ХАНДЛАГА




Зарим нөхцөлд (хэрэв эхнэр нь гадуур гарахдаа нөхөртөө хэлэхгүй бол, хэрэв эхнэр нь хүүхэддээ анхаарал тавихгүй бол, хэрэв эхнэр нь нөхөртэйгөө маргалдвал, хэрэв эхнэр нь нөхөртэйгөө бэлгийн хавьталд орохоос татгалзвал, хэрэв эхнэр нь хоолоо түлбэл) нөхөр нь эхнэрээ цохиж, зодож болно гэж үздэг 15-49 насны хүн амын хувь, хүйсээр, хот, хөдөөгөөр.

САЙХАН АМЬДРАЛЫН ХҮЛЭЭЛТ




Сүүлийн 1 жилд амьдралаа сайжирсан гэж үзсэн бөгөөд ирэх жилд мөн амьдралаа сайжирна гэж хүлээж байгаа 15-24 насны хүн амын хувь, хүйсээр, гэрлэлтийн байдлаар.

АМЬДРАЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖ



15-49 насны хүн амын амьдралын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ (0-10 хооронд үнэлсэн), хүйсээр, насны бүлгээр, 2018 он. Оноо их байх тусам амьдралдаа илүү сэтгэл ханамжтай байгааг илэрхийлнэ.


ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ, ТХЗ 10.3.1



Судалгаанаас өмнөх 12 сард ялгаварлан гадуурхалт мэдээрсэн 15-49 насны хүн амын хувь, хүйсээр, хот, хөдөөгөөр, 2018 он.


ТӨРӨЛТ, ГЭР БҮЛ ТӨЛӨВЛӨЛТ

ТӨРӨЛТИЙН НИЙЛБЭР КОЭФФИЦИЕНТ





Нэг эмэгтэй амьдралынхаа туршид төрүүлсэн хүүхдийн дундаж тоо, хот, хөдөөгөөр.

НАСНЫ БҮЛЭГ ДЭХ ТӨРӨЛТИЙН ТҮВШИН




Насны бүлэг дэх төрөлтийн түвшин, хот, хөдөөгөөр, 2018 он. Үзүүлэлтийг судалгаанаас өмнөх 3 жилийн мэдээлэлд суурилсан бөгөөд 1000 эмэгтэйд ногдхоор тооцсон.

ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ АРГА, ХЭРЭГСЛИЙН ХЭРЭГЛЭЭ



Гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай бөгөөд жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгсэл хэрэглэж байгаа (нөхөр, хамтран амьдрагч нь хэрэглэж болно) 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, арга, хэрэгслийн төрлөөр, 2018 он.


ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ АРГА, ХЭРЭГСЛИЙН ХЭРЭГЛЭЭ



Гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай бөгөөд жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгсэл хэрэглэж байгаа (нөхөр, хамтран амьдрагч нь хэрэглэж болно) 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, орчин үеийн болон уламжлалт арга, хэрэгслийн төрлөөр.


Орчин үеийн арга гэдэгт умайн гуурсан хоолой боох, үрийн суваг боох, ерөндөг, тариа, суулгац, эм, эрэгтэй бэлгэвч, эмэгтэй бэлгэвч, диафрагм, лаа, царцмаг, хүүхэд хөхүүлэх орно. **Уламжлалт арга** гэдэгт хуанлийн дагуу түр тэвчих, гадуур тавих орно.

ГЭР БҮЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХАНГАГДСАН ХЭРЭГЦЭЭ, ТӨРЛӨӨР




Төрөлт хоорондын зайгаа зохицуулах эсвэл төрөлтөө хязгаарлах гэр бүл төлөвлөлтийн хэрэгцээ нь хангагдсан гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, хот, хөдөөгөөр, насны бүлгээр, 2018 он.

ГЭР БҮЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХАНГАГДСАН ХЭРЭГЦЭЭ



Төрөлт хоорондын зайгаа зохицуулах эсвэл төрөлтөө хязгаарлах гэр бүл төлөвлөлтийн хэрэгцээ нь хангагдсан гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь.

ГЭР БҮЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХАНГАГДСАН БОЛОН ХАНГАГДААГҮЙ ХЭРЭГЦЭЭ



Төрөлт хоорондын зайгаа зохицуулах эсвэл төрөлтөө хязгаарлах гэр бүл төлөвлөлтийн хэрэгцээ нь хангагдсан гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь.

ЖИРЭМСНИЙ ТӨГСГӨЛ




Судалгаанаас өмнөх 2 жил дэх жирэмслэлтийн хувь

25.2

Амьд төрөлт	75.3
Амьгүй төрөлт	1.0
Үр хөндөлт	11.2
Зулбалт: Өсөлтгүй жирэмслэлт	6.6
Зулбалт: Бусад	5.9

Судалгаанаас өмнөх 2 жил дэх жирэмсэлсэн 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, жирэмсний төгсгөлөөр, 2018 он.


ҮР ХӨНДӨЛТИЙН ХАРЬЦАА



Үр хөндөлтийн харьцаа, хот, хөдөөгөөр.

Үр хөндөлтийн харьцаа нь судалгааны өмнөх 2 жилд хийгдсэн үр хөндөлтийн тоог тухайн хугацаан дахь амьд төрөлтийн тоонд харьцуулсан. Тэмдэглэл: Үзүүлэлтийг 1000 амьд төрөлтөд ногдохоор тооцсон.

5 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙН ТҮВШИН, ТХЗ 3.2.1, 3.2.2




Нярайн, хожуу нярайн, нялхсын, хүүхдийн, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, судалгаанаас өмнөх 5 жилээр.

Нярайн эрт үеийн эндэгдэл: төрсний дараа эхний сар дотор нас барах магадлал. **Нярайн хожуу үеийн эндэгдэл:** нялхсын болон нярайн эрт үеийн эндэгдлийн түвшний зөрүү. **Нялхсын эндэгдэл:** нэг ой хүрэлгүйгээр нас барах магадлал. **Хүүхдийн эндэгдэл:** нэгээс тав хүртэлх насны хооронд эндэх магадлал. **Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл:** төрснөөс хойш тав хүртэлх насны хооронд эндэх магадлал.

Тэмдэглэл: Үзүүлэлтүүд 1,000 амьд төрөлтөд ногдохоор тооцсон.


УМАЙН ХҮЗҮҮНИЙ ХОРТ ХАВДАР

УМАЙН ХҮЗҮҮНИЙ ХОРТ ХАВДРЫН ТАЛААРХ МЭДЛЭГ, ШИНЖИЛГЭЭНД ХАМРАГДАЛТ



Умайн хүзүүний хорт хавдрын талаар сонсож байсан, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт хамрагдсан, хариугаа авсан 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь.

УМАЙН ХҮЗҮҮНИЙ ХОРТ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛЭГ



Умайн хүзүүний эрт илрүүлэгт хамрагдаж, шинжилгээний хариугаа авсан 15-49 насны эмэгтэйчүүдийн хувь, насны бүлгээр, 2018 он.

ХҮНИЙ ПАПИЛОМА ВИРУСИЙН ЭСРЭГ ВАКЦИН

Хүний папилома вирусийн вакциныг охидод хийх нь зөв гэж үзсэн эмэгтэйчүүдийн хувь

8.7

Хүний папилома вирусийн вакцин хийлгэсэн эмэгтэйчүүдийн хувь

2.4

Хүний папилома вирусийн вакциныг охидод хийх нь зөв гэж үзсэн 20-49 насны эмэгтэйчүүдийн хувь, хүний папилома вирусийн вакцин хийлгэсэн 15-29 насны эмэгтэйчүүдийн хувь, 2018 он.

ХӨВЧ ТАСЛАХ



Хөвчөө таслуулсан 15-49 насны эрэгтэйчүүдийн хувь, өрхийн тэргүүний үндэс, угсаагаар, 2018 он.

БЭЛГИЙН ЗАН ҮЙЛ

Бэлгийн зан үйл нь нөхөн рожихүйн эрүүл мэнд, ХДХВ болон бусад бэлгийн замаар дамжих халдвар, жендэрийн тэгш байдал зэрэг эрүүл мэнд, нийгмийн асуудалд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл болдог гэж үздэг. Хүн амын бэлгийн зан үйлийн төлвийг судлах нь өвчлөлөөс сэргийлэх болон эрүүл мэндийг дэмжих бодлого, хөтөлбөрт хэрэгцээтэй мэдээллийг бий болгох юм.

Хүйс	Он	15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьталд орсон	Бэлгийн идэвхтэй амьдралтай	Бэлгийн олон хавьтагчтай	Тохиодлын бэлгийн хавьтагчтай	Бэлгэвч хэрэглэсэн
Эмэгтэй	2010	0.2	46.1	1.1	42.7	53.8
	2013	0.6	-	1.6	-	46.1
	2018	0.7	42.7	1.1	35.7	41.8
Эрэгтэй	2010	2.7	57.0	13.1	73.5	75.4
	2013	4.2	-	13.1	-	69.0
	2018	4.9	50.2	8.3	73.6	73.1

15-24 насны залуучуудын бэлгийн зан үйлийн үзүүлэлтүүд, хүйсээр.

15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьталд орсон: 15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хавьталд орсон 15-24 насны хүн амын хувь.


Бэлгийн идэвхтэй амьдралтай: Судалгаанаас өмнөх 12 сард бэлгийн хавьталд орсон 15-24 насны хүн амын хувь.

Бэлгийн олон хавьтагчтай: Судалгаанаас өмнөх 12 сард нэгээс олон хүнтэй бэлгийн хавьталд орсон 15-24 насны хүн амын хувь.

Тохиодлын бэлгийн хавьтагчтай: Судалгаанаас өмнөх 12 сард тохиодлын бэлгийн хавьталд орсон 15-24 насны хүн амын хувь.

Бэлгэвч хэрэглэсэн: Судалгаанаас өмнөх 12 сард тохиодлын бэлгийн хавьталд орсон бөгөөд хамгийн сүүлийн бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн 15-24 насны хүн амын хувь.

ХДХВ/ДОХ-ЫН ҮЗҮҮЛЭЛТ




ХДХВ дамжих 2 аргыг (ХДХВ-ийн халдваргүй, бэлгийн нэг үнэнч хавьтагчтай байх, бэлгийн хавьталд орох бүртээ бэлгэвч хэрэглэх) мэддэг, эрүүл харагдаж байгаа хүн ХДХВ-ийн халдвартай байж болно гэдгийг мэддэг, ХДХВ/ДОХ-ын талаарх 2 ташаа ойлголтыг үгүйсгэсэн хүн амын хувь, насны бүлгээр, хүйсээр, 2018 он.

1) Хэрэв ногооны худалдагчийг ХДХВ/ДОХ-ын халдвартай гэж мэдвэл түүнээс ногоо худалдаж авахгүй, эсвэл 2) ХДХВ/ДОХ-ын халдвартай хүүхэд эрүүл хүүхдүүдтэй хамт суралцахыг хүлээн зөвшөөрөхгүй гэж хариулсан хүн амын хувь, насны бүлгээр, хүйсээр, 2018 он.

Судалгаанаас өмнөх 12 сард ХДХВ/ДОХ-ын шинжилгээ өгч, хариугаа авсан хүн амын хувь, насны бүлгээр, хүйсээр, 2018 он.

ХДХВ/ДОХ-ЫН ҮЗҮҮЛЭЛТ



ХДХВ/ДОХ-ын талаар сонссон, цогц мэдлэгтэй, судалгаанаас өмнөх 12 сард ХДХВ-ийн шинжилгээ өгсөн 15-49 насны хүн амын хувь, хүйсээр. Тэмдэглэл: 2010 оны судалгааны эрэгтэйчүүдийн үзүүлэлт 15-54 насны хувьд тооцогдсон.

Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ) нь Нийгмийн Үзүүлэлтийн Түүвэр Судалгаа (НҮТС)-г 2018 онд Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа (ОУБТС)-ны олон улсын 6 дахь хөтөлбөрийн хүрээнд НҮБ-ын Хүүхдийн Сан болон НҮБ-ын Хүн Амын Сангийн арга зүйн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан.

Энэхүү инфографик нь НҮТС 2018-ын зарим үр дүнг танилцуулах зорилготой бөгөөд энд багтсан мэдээллийг тайлангийн дараах хүснэгтүүдээс авах боломжтой: SR.1.1, SR.3.1, SR.4.1, SR.11.1, TC.4.1, TC.4.4, TC.4.6, TC.4.7, TC.9.1, WS.1.1, WS.1.2, WS.1.8, WS.3.6, TM.3.1, TM.4.2, TM.6.1, TM.6.2, TM.7.1, TM.8.4, TM.8.6, PR.1.1, TM.8.9, TM.4.1, TC.7.1, TC.7.3, TC.7.6, TC.7.7, TC.1.1, TC.8.1, TC.10.1, TC.11.1, TC.10.2, LN.1.1, LN.1.2, LN.2.3, LN.2.7, PR.2.1, PR.2.2, LN.4.1, LN.4.2, LN.2.4, LN.2.6, PR.3.3, PR.4.1W, PR.4.1M, PR.7.1W, PR.7.1M, PR.6.1W, PR.6.1M, PR.6.5W, PR.6.5M, PR.6.4W, PR.6.4M, SR.10.1W, SR.10.1M, SR.10.3W, SR.10.3M, SR.9.3W, SR.9.3M, TM.1.2, EQ.3.1W, EQ.3.1M, EQ.4.1W, EQ.4.1M, SR.9.1W, SR.9.1M, SR.9.4W, SR.9.4M, PR.7.1W, PR.7.1M, PR.6.1W, PR.6.1M, PR.6.5W, PR.6.5M, PR.6.3W, PR.6.3M, PR.8.1W, PR.8.1M, EQ.4.2W, EQ.4.2M, TM.1.1, TM.1.2, TM.3.3, TM.14.1, TM.14.3, TM.13.1, TM.13.3, TM.12.1, TM.11.1W, TM.11.1M, TM.11.3W, TM.11.3M, TM.11.4W, TM.11.4M, TM.11.7W, TM.11.7M, TM.10.1W, TM.10.1M, TM.10.2W, TM.10.2M.

НҮТС 2018-ын үр дүнгийн тайланг www.1212.mn, мөн бусад улс орны ОУБТС-ны баримтын хуудас болон тайланг mics.unicef.org/surveys цахим хуудаснаас харах боломжтой.

Ашигласан загвар, зурган материалууд: Smashicons, Good Ware, bqlqn, Freepik, DinosoftLabs, Eucalyp, Vectors Market, Icon Pond, Icongeek26 - www.flaticon.com

БОЛОВСРУУЛСАН:

С.Тодгэрэл, НҮТС-ны багийн ахлагч, ҮСХ-ны Хүн ам, нийгмийн, статистикийн газар (ХАНСГ)-ын статистикч
Т.Алтанцэцэг, НҮТС-ны багийн гишүүн, ҮСХ-ны ХАНСГ-ын статистикч
Ш.Сэнгүм, НҮТС-ны багийн гишүүн

